# МОНГОЛ УЛС
# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр    Дугаар А/290    Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын өмгөөлөгчдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэж, хамтран ажиллах хүрээнд Хангайн бүсийн өмгөөлөгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөний үер тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуй нэгж, иргэдэд сургалт зохион байгуулах зардалд 7,000,000 (Долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 7,000,000 (Дөлөөн сая) төгрөгийг Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөрийн “Тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжид хяналт хэрэгжүүлэх зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Зардалтай холбоотой шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)- д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА    П.ЛХАГВАЖАВ

6712011167

Захирамж2024